



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/11

Мандалговь

Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 234 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдын 2016 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 46 дугаар тушаалын 2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхийг салбар зөвлөлийн дарга О.Чулуунбат /Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга/- д үүрэг болгосугай.

Гурав. "Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай" аймгийн Засаг даргын 2016 оны 06 сарын 20-ны өдрийн А/245 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000015